

ХҮМҮҮС

Б.ГАНБОЛД: Бүтээл туурвиж, олны “өгөөш” болж буйдаа туйлын баяртай байна

Д.ХҮСЛЭН

Надтай ярилцаж суугаа эрхэм бол хүний далдын далд амтлах сан гэж хүсэх бал бурам, холуур л тойроосой гэх айдас, хүсдэг ч үйлдэж эс чадах танхайрлыг жишим ч үгүй дэлгээж, хүмүүсийн алга ташилт, хараалыг зэрэгцүүлж “буулгадаг” нэгэн. Хүний асуудал хэзээ ч барагдахгүй. Бас даван туулах хүч, ухаан ч мөхөс билээ л. Тиймээс уран бүтээлчдэд туурвих өнцөг, хөндөх сэдэв хэзээ ч мундахгүй биз. Тэрбээр “Орхидос”, “Намаг”, “Хоёр амь”, “Улаан дөрвөлжин”, “Тэнгэрийн андгай”, “Пагмадулам” зэрэг 10 гаруй киног найруулсан. Ингээд түүнтэй ярилцсанаа уншигч танд хүргэе.

- “Пагмадулам” нээгээд удаагүй байна. Эцэст нь харахад эл бүтээл таны санаанд хүрэв үү?

- “Монголын эмэгтэйчүүдийн холбоо”-ны 100 жилийн ойд зориулж энэ сод эмэгтэйн тухай кино хийх гэж нэлээд цаг хугацаа, ур чадвар зарлаа. Гагцхүү өнөөгийн эмэгтэйчүүдийн дуу хоолой болохуйц түүхэн эмэгтэйн түүхийг баримт нотолгоонд тулгуурлаж хийсэн нь талархууштай юм. Уг холбоог улсын өмчит байгууллага гэж ойлгодог. Гэхдээ энэ чинь төрийн бус байгууллага. Кино хийх нөр их хөрөнгийг босгох гэж хичээсэн тэдэнд талархал илэрхийлэх хэрэгтэй байх.

Сэтгэл ханамжид уран бүтээлч биш үзэгчид дүн тавьдаг. Үзэгч бүрийн сэтгэлгээ, харах өнцөг өөр. Би Д.Пагмадуламын тухай гэхээс илүүтэй эмэгтэй хүний тухай кино хийхийг хүссэн уран бүтээлч. Киногоо үзчихээд 100 хувь сэтгэл хангалуун байна гэдэг хэцүү. Олон шалгуур давсны дараа уран бүтээлээ хийнэ. Шалгуурын цаана бэрхшээл бий. Жүжигчдийн ур чадвар, бусад уран бүтээлчийн ажилд бүрэн дүүрэн сэтгэл хангалуун байна. Харин би уг киног 60 хувьтай хийсэн гэж өөрийгөө үнэлнэ. Уран бүтээлч хүн аль болох алдахгүйг зорьдог байх. Тэгэхийг л хичээлээ.

- Кино тэр чигтээ өнөө өрнөж буй үйл явдлыг өнгөрсөнтэй нь “уяж” үзүүлж байгаа шүү дээ. Нацагдорж Пагмадуламыг анх олж хардаг хэсэг шууд л “Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэгийг санагдуулам юм билээ.

- Хүн үргэлж амьдралынхаа хамгийн баяртай, хүнд хэцүү үеийг зэрэгцүүлэн бодож явдаг. Энэ бол баяр зовлон хоёрын дундуур хийх гэж хичээсэн бүтээл. Нөгөөтээгүүр,

уг бүтээл бол Д.Нацагдоржийн, бус Д.Пагмадуламын тухай кино гэдгийг онцгойлж хэлмээр байгаа юм.

- Та дэлгэцийн урлагт хамгийн сайхан эмэгтэйчүүд, залуучуудаас илүү мэргэжлийн бөгөөд даруу төлөв авьяастнуудтай түлхүү ажилладаг шиг харагддаг. Энэ удаад А.Номин-Эрдэнэ ихэмсэг, бие даасан дүрээр тодроод ирлээ.

- Зохиол дахь дүрийг амилуулж чадах жүжигчнийг олох нь нэн тэргүүний хэцүү ажил. Асар туршлагатай хүн сонгохоос илүү хэн үүнийг дүр болгож чадах вэ гэдэг чухал. Мэдээж мэргэжлийн байх хэрэгтэй. 150 гаруй үзэгдлийн 120 орчимд тоглоно гэдэг гол дүрийн жүжигчний хувьд том ачаа, хариуцлага. Түүхэн эмэгтэйн дүр учраас ерөнхий чиг шугамаа тодорхой болгох ёстой. Нэн ялангуяа, найруулагч жүжигчинтэйгээ найз мэт ярилцаж, тархинд бүрэлдсэн дүрээ тултал ойлгуулах нь гол асуудал байгаа юм. Тэгж байж миний хүссэнд хүртэл тоглож, жүжигчний ур чадварынхаа нандин мэдрэмжийг дүрдээ шингээж чадна. Энэ нь авьяастай ч холбоотой.

Д.Нацагдоржийн дүрд ажилласан О.Мөнгөн-Очир гээд залуу бий. Маш энгийн. Бид зөндөө орилж, хашхирч тоглож ханалаа. Юм энгийн байх тусмаа хүмүүст ойрхон. Юуг ч гоёчлох шаардлагагүй. Нэр нүүртэй жүжигчнийг гол дүрд сонгох нь чухал биш. Шинэ залуу үеийнхэнтэй ажиллах нь найруулагчаас тодорхой ур чадвар шаардах байх. Ямартай ч жүжигчдээ өөрийнхөө хэмжээнд “тамгалчихлаа”.

- Нээлтийн үзвэрээс хойш олон л шүүмж өрнөлөө. Харин та үүнд би Д.Нацагдоржийн бус, Д.Пагмадуламын, бас эмэгтэй хүний тухай кино хийсэн гэж хариулж байна. Гэхдээ энэ түүхийн салшгүй хэсэг нь тэдний яндашгүй их хайр нь. Зарим найруулга логик зөрчилтэй, илэрхийлэх санаагаа хөнгөн шүргээд л өнгөрсөн тал анзаарагдсан.

- “Д.Нацагдоржийг архичин шиг доройтууллаа”, “Их зохиолч хаачив” гэж. Найруулагч киногоо аль өнцгөөс харж хийхдээ л байгаа юм. Гайтай юм шиг тэд ингэж танилцаагүй бол зовох байсан уу, үгүй юу. Тэгэхээр нэг талаараа энэ бол үйлийн үр. Нөгөөтээгүүр, Д.Нацагдоржийг Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгчдийн нэг гэдгийг бид хангалттай мэднэ. Шүлгээр нь ч хүмүүжсэн. Гэхдээ аливаа зүйлд хэм хэмжээ гэж бий. Ер нь яагаад бүх юм нэг хүний сүүдэр шиг байх ёстой юм. Энэ бүтээлд Д.Нацагдоржийн хэсгийг жаахан л нэмчихвэл түүний тухай кино болно. Юм эргэхдээ маш амархан. Тэгэхээр Д.Пагмадулам Д.Нацагдоржийн сүүдэр болчих гээд байгаа биз. Тэр утгаараа би энэ эмэгтэйн хувь хүнийг хадгалахыг хичээсэн.

Түүнээс биш Д.Нацагдоржийг үгүйсгээгүй. Тийм зохиолч, яруу найрагч дахиж төрөхөд хэцүү байх. Уран бүтээл хүн бүрд таалагдах албагүй. Гэхдээ шүүмжлэгчид голыг нь олж хэлдэг байвал таатай байна. Шүүмжлэл, магтаал бүрд хариулаад явдаг хүн би биш. Би ажлаа 60 хувьтай хийлээ гэж хэлсэн дээ. 60 гэдэг бол 50 хувиас илүү гэсэн үг. Би ололттой байна гэж харж байгаа. Кино үзэгчид Д.Пагмадуламыг олж харсан байна шүү дээ. Намайг юу гэж ч хэлж болно. Харин миний сүнслэг байдал, гүн ухаан маань байгаа оносон байна.

Би шинэ юм зохиолгүй, ул суурьтай бүтээл хийхийг хүссэн. Түүхийг шинээр бичиж, бас устгаж болно. Би нэг ярилцлагад ч мөн ингэж хэлсэн. Нэг зүйлээ давтаад байгаадаа биш. Архивын баримтад Д.Пагмадуламыг хүүхэдгүй гэдэг ч “Энэ хүн манай эмээ байсан” гэх хүн байна. Тиймээс бид алтан дунжийг л барина шүү дээ. Түүхч, судлаач нар нэг үзэл баримтлалтай гэхэд тун эргэлзээтэй. Асуудлыг тус тусын өнцгөөс харж байдаг. Би яригдаж байна гэдэг чинь “Пагмадулам”-ыг хийснийхээ үр дүнг амсаж буй хэрэг. Ингэж асуусанд баярлалаа.

- Түүхэн намтарчилсан кинонд ажиллах нь найруулагчид том ачаа болох тодорхой. Үүний хүрээнд хоёр асуудал яригдана. Хэт уран сайханжуулсан худлаа, гуйвуулсан зүйл үзүүлж болохгүй. Ялангуяа тус кинонд хувь эмэгтэйн намтраас гадна хэлмэгдүүлэлтийн хар барааныг ч өгүүлж буй шүү дээ. Тиймээс хүнийг дэлгэцээр дамжуулж дахин хэлмэгдүүлэх вий гэх сэрэмж ч яригдах нь зөв болов уу.

- Тэнэг хүн зоригтой гэдэг шиг зүйл болчихгүй юу. Зоригтой дуугарах ёстой ч хэм хэмжээндээ байх хэрэгтэй. Уран бүтээлч хүн түүхэнд байхгүй зүйлийг бий болгох нь хийхээсээ илүү доромжлол байх. Гэхдээ уран сайхны арга байх ёстой. Д.Пагмадуламын брэнд болсон ганц зураг бий. Энийг янз янзаар л хэлдэг. Олон брэнд өмсчихсөн гэдэг ч юм уу. Нөгөөтээгүүр, үүнийг ил захидлын фото зураг гэдэг. Гэхдээ ил захидлын баримт сэлт байдаггүй. Судалгаа хийж байхад “Энэ яг Д.Пагмадулам мөн үү” гэх эргэлзээ гарах үе ч бий.

Түүнийг хар тамхи татдаг байсан, шоронд ороод тэмбүү туссан, хятад хүнтэй суусан гэх. Би үүнийг кинондоо оруулж болно. Ингэснээрээ гаж болчих юм биш. Хэрвээ тэгвэл намайг булшилна л даа. Учир нь бүтээл үнэ цэнтэй, зөвтгөлтэй байх ёстой. Магад тэр тэнгэрээс хардаг бол баярлахаар зүйл хийсэн гэж хэлнэ. **Би энэ киног**

өөрийнхөөрөө, танхай хашхирч хийлээ. Харин бүтээлд уран сайхны дүр бий болж байж сайн хөрвүүлж чадна.

- Жишээ нь Батын дүр.

- Тийм. Амьдралд хайрын гурвалжин байдаг нь бичигдээгүй түүх. Хүн төрөлхтөн үүнийг зөвхөн Уильям Шекспирээр төсөөлдөг байж болно. Хүний амьдрал урьдаас бичигдсэн нэг л тойрогт өрнөдөг. Тэрнээс гажууд амьдардаг нь ч цөөхөн байх.

Сод төрөгсөд их бага настай байдаг шиг. Ертөнц хүнд өгөгдөл өгдөг. Энэ бол маш том шагнал. Маш бага амьдарч том амжилтад хүрээд зайл гэж байгаа юм шиг. Урт насалж байгаа хүмүүсийг үгүйсгээгүй л дээ. Киноны төгсгөлд “Намайг Пагмадулам гэдэг юм аа” гэдэг нь тэр чигтээ энэ киноны тунхаг. Миний амьдрал энэ шүү гэж байгаа хэрэг.

Зохиолд бичигдээгүй 15-16 нэмэлт үзэгдэл авсан. Зураг авалтын турш авсан бүх дүрсээ оруулах шаардлага байдаггүй. Тэгж байж кино илүү амьтай болно.

- Зарим уран бүтээлч эрүүл саруул шүүмжийг хүртэл “Энэ ер нь хэн юм бэ” гэж хардаг бололтой юм. Кино хийж байж киночдыг шүүмжлэх эрхтэй болдог юм биш. Үзэгчдэд эцсийн бүтээлийн чанар чухал болохоос та бүхний ямар зовлон туулж киногоо бүтээсэн чинь хамаагүй л дээ.

- Би шүүмжид нэг ч удаа хариу өгч үзээгүй хүн. Уран бүтээлчдийн зовлон хэнд ч хамаагүй. Хүсэж хийж байж.

- Тэгвэл яагаад ялархаад байдаг юм бэ?

- Өчүүхэн байна. Тэр хэрээрээ хүнд олзлогдож байгаа. Ундууцаж 10 хүнтэй хэрүүл чинь илүүдээ гарсан зав. Киног театр шиг эргэж засах ямар ч боломжгүй. Нэг л агшин шүү дээ. Эго, амбиц хүнд хэрэгтэй ч хаана гаргах вэ гэдэг чухал. Доромжлуулж сур л даа, яасан эмзэг юм бэ. Хүмүүс бичиж байг л дээ. Нэг нь чимээгүй болчихоор хэрүүл зогсдог биз дээ.

- Гэхдээ авахаа авах ёстой.

- Тийм. Ер нь киноны уран бүтээлчдийг биш найруулагчийг л хараах хэрэгтэй л дээ. Алдъя гэж кино хийдэг найруулагч байхгүй л байх. **Уран бүтээлээрээ дамжуулж шударга үнэн амьдрах хэрэгтэй.** Хүнд таалагдах гэж “юм” хийвэл үхэл рүүгээ ойртож байна л гэсэн үг.

- Д.Пагмадуламыг цагаатгасан бил үү? Энэ тухай шүүхийн шийдвэр олсонгүй.

- 2019 оны гуравдугаар сард цагаатгах шийдвэр гаргасан. Түүхч, судлаач Х.Мэндсайхан их хөөцөлдсөн юм билээ.

- Та “Би өөрийнхөө хувьд тултал ажилласан учраас дараа нь хэн юу ч гэсэн хамаагүй” гэдэг хүн шиг. Заримдаа муу юм хийчихлээ дээ гэж хямардаггүй юу?

- Би үзэл бодлоосоо ухардаг хүн биш. Бүтээлүүдээ эргэж үзэхээр алдаа харагддаг ч шүүмжлэхээс илүү сайжруулахыг хичээдэг. Хэдэн сарын дараа “Пагмадулам”-аас алдаа олж харна, ойлгомжтой. Энэ чигээрээ би хэдэн нас хүртлээ сурахаа мэдэхгүй байна. Харин одоо нэг зүйл хэлчихье. Би одоо л кино хийж сурч байна даа.

- Авьяасаас гадна сахилга бат, төлөвлөлт ч чухал байх.

- Маш олон уран бүтээлчтэй ажиллалаа. Янз янз л байдаг. Ямар ч ажил мэргэжлийн холбоонд хариуцлага хамгийн чухал.

- Кино зохиол бичиж байх үе, бүтээл үзэгчдэд хүрсний дараа гэсэн өөр өөр хэмжээснүүд дунд аясаараа л шилжиж гарна гэдэг хэцүү байдаг уу?

- Кино бүр янз янзын хугацаанд хийгдэнэ. Энэ бүхэн дуусчихаар их эзгүйрчихдэг юм. Тэрнээс ангижрахын тулд дараагийнхаа ажил руу бушуухан орох ёстой болов уу. Би “Пагмадулам”-ыг хийсэн гээд сар гаруй архи уугаад явалтай биш дээ. Нэг бүтээл гаргачхаад ханаж цадаад, дахиж амьдрахгүй юм шиг байж болохгүй. Үзэгчдийн хүлээлтийг ямар ч уран бүтээлч гүйцдэггүй тул хортой маркетинг, сурталчилгаа хийж өөрсдийгөө нулимдгаа болих л хэрэгтэй. Надад өөрийгөө рекламдах шаардлага алга.

- Та нэг ярилцлагадаа “Уран бүтээлээрээ дамжуулж ангижирдаг” гэсэн байна билээ. Юунаас тэр вэ?

- Нийгмийн асуудлыг илэрхийлдгээрээ дотоод сэтгэл минь жаахан ч гэсэн зовлонгоос ангижирдаг. Чи “Улаан дөрвөлжин” гэж кино үзсэн үү?

- Үзсэн.

- Таван жил бодож зохиолыг бичсэн кино байгаа юм. “Пагмадулам” бол миний найруулсан дөрөв дэх түүхэн кино.

- Та жүжигчин, найруулагч гэсэн хос мэргэжилтэй шүү дээ. Заримдаа жүжигчдэдээ өөрөө жүжиглэж үзүүлдэг гэсэн.

- Би ийм зүйл хүсэж байна гээд үзүүлнэ шүү дээ. Үг, үйлдлийг биеийн хэлэмжтэй хослуулаад хэлчихсэн байхад болдог юм. Хамгийн чухал нь ойлгуулах.

- Сэтгэлзүйн драма, триллер төрлийн кино таны бүтээлүүдэд зонхилдог.

Шалтгаан нь юу юм бэ?

- Найруулагч бүр бүх төрлөөр бүтээл хийж үзэх ёстой байх. Өөрийгөө олно. Надад драма их ойрхон байдаг юм. 10 настайдаа өнчин хоцорсон болоод ч тэр юм уу. Зовлонг жаахан ч гэсэн амссан учраас дөхөм байдаг болов уу. Би өөрийгөө олсон, эсэхээ сайн мэдэхгүй байна. Олох гэж хичээж яваа л нэгэн байх. Одоохондоо би инээдмийн кино хийгээгүй байна. Бид нарын хийж байгаа инээдмийн кино бол туйлын эмгэнэл.

- Кино шигээ зан чанартай гэж үү?

- Өөрийн санаагаа кинондoo “нааж” байгаа учраас уншигдах байх. Чи анзаарсан бол “Пагмадулам” дээр эмэгтэй хүний цог, гэрэлтэй нүд, дээшээ чиглэсэн харсан харцны тавилт их байгаа. Нацаг, Пагма хоёр өөд өөдөөсөө харж уйлдаггүй. Нэгэндээ нулимсаа үзүүлдэггүй. Эрчүүд зовж болно. Харин найруулагчийн хувьд хэлэхэд эмэгтэй хүн зовох учиргүй.

- Тэгэхээр чинь эрчүүдийг хэн хайрлах юм бэ?

- Юунд хайрлуулах гээд байдаг юм.

- Яагаад?

- Сайн эрэгтэй хүнийг хайрлана. Би ч нэг их сайн хүн биш л дээ. Хүнд хайрлагдах зүйл хийж байж л хайрлагдана. Эрэгтэй хүн өөрөө өөрсөө гутарч л зовдог байх даа. Харин сэтгэл гундах үе гэж байна. Гэхдээ өөрийнхөө зовлонг өөрөө үүрэх ёстой. Би ийм л үзэл бодолтой хүн.

- Та ойрд хэр их монгол кино үзэж байна вэ?

- Үзэж амжихгүй л явна.

- Хувь уран бүтээлч багаа хэрхэн бүрдүүлэх нь тэдний шийдэх хэрэг. Гэхдээ муу зохиолоо “гавьяат”-уудаар халхалсан, гялс мөнгө олчихъё гэсэн кино IPTV-ээр дүүрэн байх шиг.

- Чиний хэлж буйгаар бодвол би “Пагмадулам”-ыг хийхдээ нэг ч косметик ашигласангүй. Кино театрт болон IPTV-д гарах хоёр 40-60 сая төгрөгийн зөрүүтэй.

Дээрээс нь кино контент гэх нэршил байна. Кино юм уу, контент юм уу. Хүмүүс кино театрт очихоо больсон нь уран бүтээлчидтэй л холбоотой. Сэтгэлгээний, үлдэцтэй бүтээл хийвэл энэ аяндаа цэвэршинэ. Аливаа зүйлийг ингээд шүүмжлэхээр амьдрах гэж байгаа нэгнээ доромжилсон юм болно. Гэхдээ хэлэхэд гэмгүй.

- Би ер нь юуны төлөө кино хийгээд байсан юм бэ гэж бодогдсон үе байсан уу?

- Тийм. Амьдралыг олон өнцгөөр тайлбарлахаас илүү “Яах гэж”, “Юуны тулд” гэж асуух чинь аймшигтай.

- Одоо та ямар кино хийхийг хүсэж байна вэ?

- Тэрийг ярих нь илүүц. Юу ч болоогүй байхад баахан хөзөр нээгээд яах вэ. Сүртэй нууцлаад байх юм байхгүй ч цаг нь ирэхээр харагдана. **Би чимээгүй бүтээхийг хүсдэг нэгэн.** Бүтээлийг сайн муу болохыг хэн ч таашгүй. **Бүтээл туурвиж, олны өгөөш болж байгаадаа туйлын баяртай байна. Дуугүй байвал харин ч гомдмоор шүү. Тэртээ тэргүй миний морь эргэж ирэхгүйгээр давхисан.** Эргэж ирэхгүй зүйлийн араас би хөөцөлдөнө гэж байхгүй. Миний гурван сая монголчууд нэгнээ бага нулимж амьдармаар байна. Нэгнээ доромжилсоор байгаад доромжлох ч хүн олдохоо болилоо. Эцэстээ хоёр гүрэн рүүгээ орж байна шүү дээ. Хэр хэмжээндээ байх шиг сайхан юм байхгүй.